ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗАР

# 2023 ОНД ХЯНАЛТАД АВСАН ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ

2023 оны 12 дугаар сарын 11 Улаанбаатар хот

| Шийдвэрийн дэс дугаар | Зүйл, заалтын дэс дугаар | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Шийдвэрийн холбогдох заалтын агуулга | Хэрэгжилтийн явц | Үнэлгээ, (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал) |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| **НЭГ. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ** | | | | | |
| 1. | 8.2.1. | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай 2021-12-17 Дугаар 2021.12.17 | эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн; | Байгууллагын албан ёсны https://standard.ub.gov.mn цахим хуудас, мэдээллийн самбарт байгууллагын эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлс, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээллийг тогтмол байршуулж байна. | 100% |
| | 8.2.2. | | чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг; | Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар татан буугдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” А/1649 дүгээр захирамжаар байгууллагын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт орсонтой холбогдуулан үндсэн чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн байршуулсан. | 100% |
| | 8.2.5. | | хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан; | Нийслэлийг хөгжүүлэх богино, дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан газрын чиг үүрэгт хамаарах зорилт арга хэмжээний хэрэгжилтийг хангуулж, биелэлтийг улирал бүр тогтмол тайлагнаж байна. Үүнд:<br>- “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичигт 4 зорилтын 5 арга хэмжээ; | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | | - "Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2023 оны төлөвлөгөөнд 1, хамтран хэрэгжүүлэх 8 буюу нийт 9 арга хэмжээ;<br>- Нийслэлийг хөгжүүлэх 2023 оны хөгжлийн төлөвлөгөөнд хариуцан хэрэгжүүлэх 6, хамтран хэрэгжүүлэх 3, нийт 9 арга хэмжээ тусгагдсан.<br>Тайланг байгууллагын албан ёсны https://standard.ub.gov.mn цахим хуудаст "Бодлогын баримт бичгийн биелэлт" хэсэгт тогтмол байршуулж байна. | |
| | 8.2.6. | | үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт; | Байгууллагын цахим хуудасны Хууль эрх зүй буланд үндсэн үйл ажиллагаатай холбоотой холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, Тушаал, шийдвэр буланд холбогдох дээд газрын тушаал шийдвэр, Нийслэлийн Засаг даргын захирамж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдааны тэмдэглэл, газрын даргын үндсэн үйл ажиллагаатай холбоотой баталсан А тушаалыг тогтмол шинэчлэн байршуулж ажиллаж байна. | 100% |
| | 8.2.7. | | албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг; | Албан тушаалын тодорхойлолтууд шинээр батлагдсантай холбогдуулан вэбсайтад шинэ хуудас хөгжүүлж байршуулсан. "Холбоо барих" хуудсанд нийт албан хаагчдын нэр, ажлын утасны дугаарыг байршуулж, тогтмол шинэчлэсэн. | 100% |
| | 8.2.8. | | өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ; | Байгууллагын албан ёсны https://standard.ub.gov.mn цахим хуудаст албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээллийн тогтмол байршуулж байна. | 100% |
| | 8.2.10. | | мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр. | Байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд мэдээлэх зорилгоор, байгууллагын цахим хуудас болон олон нийтийн сүлжээгээр 7 хоног бүр тогтмол мэдээ, мэдээллийг иргэд, олон нийтэд зориулж байгууллагын | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | | олон нийтийн цахим сүлжээ /пейж хуудас/-нд 406 мэдээ, вэб хуудаст 134 мэдээ оруулав. | |
| | 8.3.1. | | ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл; | 2023 онд төрийн захиргааны албан тушаалын сул орон тоог 6 удаа нээлттэй зарлаж, нутгийн захиргааны байгууллага хооронд зарлан, зохион байгуулсаны үр дүнд сонгон шалгаруулалтаар удирдах, гүйцэтгэх албан тушаалын тусгай шалгалтыг 18 албан хаагч өгч тэнцсэний дагуу албан тушаалд нь жинхлэн томилж ажиллуулсан. | 100% |
| | 8.3.3. | | албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм; | Төрийн албан хаагчдын ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ыг мөрдлөг болгон газрын даргын 2022 оны А/10 дугаар тушаалаар шинэчлэн баталсан байгууллагын "Ёс зүйн дотоод дүрэм"-ийг албан хаагчдын ажлын байр болон байгууллагын цахим хуудсанд байршуулж мөрдөн ажиллаж байна. | 100% |
| | 8.3.4. | | хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам; | Байгууллагын 2023 оны "Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг газрын удирдлагаар 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдөр батлуулж хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Төлөвлөө, түүний хагас жилийн биелэлтийг байгууллагын https://standard.ub.gov.mn цахим хуудасны "ил тод байдал" цэсэд байршуулан ил тод байдлыг хангуулсан. | 100% |
| | 8.3.5. | | хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ; | Байгууллагын цахим хуудсанд төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2023 оны хөтөлбөр, сул орон тоонд сонгон шалгаруулалт зохион байгуулах 6 удаагийн зар мэдээлэл, төрийн байгууллага хооронд шилжүүлэн ажиллуулах 4 удаагийн зар мэдээлэл, шинэчлэгдсэн бүтцийн танилцуулга, орон тоо зэрэг 11 төрлийн дата мэдээллийг тус тус байршуулан байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангуулсан. | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | 8.4.2. | | төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан; | Байгууллагын цахим хуудсанд Санхүүгийн тайлангийн аудитын тайланг 2019 оноос тогтмол байршуулж байна. | 100% |
| | 8.4.10 | | төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан; | Газрын 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 8 бараа ажил, үйлчилгээг худалдан авахаар боловсруулан батлуулж худалдан авах ажиллагааны tender.gov.mn цахим системд нийтэлсэн. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу шууд худалдан авалт болон тендер шалгаруулалтыг зохион байгуулан ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан. Үүнд.<br>1. Авто зам, замын байгууламжийн 2 хотын стандартын төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээ<br>2. Үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, үнэлгээний хөтөлбөр, арга зүй боловсруулах судалгаа<br>3. Хотын стандартыг сурчлан таниулах контент багц 1 боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээ<br>4. Хотын стандартыг сурчлан таниулах контент багц 2 боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээ<br>5. Хотын стандартыг сурчлан таниулах контент багц 3 боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээ<br>6. Хэвлэлийн ажил гүйцэтгэх гэрээ | 90% |
| | 8.6.1. | | олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс ирсэн санал; | 2023 онд боловсруулж буй дараах хотын стандартын төслүүдэд байгууллагын https://standard.ub.gov.mn/ цахим хуудсаар дамжуулан иргэд, олон нийтээс санал авч байна. Үүнд:<br>- Оршуулгын газрын орчны эрүүл, аюулгүй байдлын ерөнхий шаардлага<br>- Хөв цөөрөм үүсгэх болон хур тунадасны усыг хуримтлуулах, дахин ашиглахад тавигдах шаардлага | 100% |
| 2. | 616 | Төрийн албаны тухай | 55.3. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах | 2023 оны “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-т 4 | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | /Шинэчилсэн найруулга/ 2017-12-07 Дугаар 2019.01.01 | нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ. | бүлгийн 12 арга хэмжээг төлөвлөн батлуулж, хэрэгжилтийн ханган ажиллаж байна. Албан хаагчдыг мэргэшүүлэх хүрээнд "Удирдлагын академи" сургуулийн Мэргэшүүлэх багц сургалтад 10, Нийслэлийн хүний нөөцийн хөгжлийн төвийн төлөвлөгөөт сургалтад 45, Худалдан авах ажиллагааны сургалтад 9, Мэргэжлийн сургалт семинарт 8 албан хаагчийг тус тус хамруулж, суралцах боломж нөхцлөөр ханган ажилласан.<br>Албан хаагчдын ажиллах таатай нөхцлийг бүрдүүлэх хүрээнд албан тасалгааны хуваарилалт хийж ажлын уялдаа холбоог хангуулан ажлын уян хатан цагийн горимыг бүрдүүлэн өгч ажилласан. | |
| 3. | 19.1.8. | "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай" 2011.02.02 Дугаар 2011_02_02 | Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагад ажиллагсдын хүйсийн тэнцвэртэй байдлын тайланг сум, дүүргийн Засаг дарга дараа оны 01 дүгээр сарын 10-ны дотор аймаг, нийслэлийн Засаг даргад, аймаг, нийслэлийн Засаг дарга дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор Жендэрийн үндэсний хороонд тус тус хүргүүлэх; | Монгол Улсын Засгийн газар, Жендерийн үндэсний хорооноос зохион байгуулж буй үндэсний хэмжээний "Харилцан хүндэтгэе" нэг сарын аянд нэгдэж, зохион байгуулсан үйл ажиллагааны тайлан, биелэлтийг 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдөр 01/234 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.<br>2023 оны 11 дүгээр сарын 25-наас 12 дугаар сарын 10-ны өдрүүдэд зохион байгуулагдаж буй "Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян"-д нэгдэж, хүчирхийллийг таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр уриалга постер гарган түгээж, байгууллагын хэмжээнд холбогдох нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөж байна. Аяны хүрээнд зохион байгуулсан арга хэмжээний тайлан мэдээг 2023 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн дотор Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхээр боловсруулан ажиллаж байна. | 90% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| 4. | 10.1. | “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай” 2023.05.04 | Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиг үүргийг Ёс зүйн хороо, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороо, томилох эрх бүхий албан тушаалтан хэрэгжүүлнэ. | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг байгууллагын хэмжээнд мөрдүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлж, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбогдуулан гаргасан иргэн, хуулийн этгээдийн гомдол мэдээллийг хянан шалгах, хариуцлага хүлээлгэх эсэх талаар дүгнэлт гаргах эрх бүхий Ёс зүйн дэд хороог газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн А/59 дүгээр тушаалаар байгуулсан. | 100% |
| | 13.2. | | Нийт албан хаагчдын олонхын дэмжлэг авсан хүнийг Ёс зүйн дэд хорооны гишүүнээр таван жилийн хугацаагаар сонгоно. | Байгууллагын хэмжээнд нийт 8 хэлтэсээс хаалттай санал хурааж олонхын саналаар дарга, гишүүд-3, нарийн бичгийн дарга, нийт 5 гишүүний бүрэлдэхүүнтэй “Ёс зүйн дэд хороо”-г байгуулсан. | 100% |
| 5. | 9.1. | “Төрийн хяналт шалгалтын тухай” 2003.01.03 | 9.1.Хяналт шалгалтын байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:<br>9.1.1.хуульд заасны дагуу хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт, техникийн зохицуулалт,стандартын биелэлтэд хяналт тавих; | Барилга, дэд бүтцийн салбарт хамаарах 11 хяналтын чиг үүргийг нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлж, салбарын хууль тогтоомж, стандартын хэрэгжилтэд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн дагуу хяналт тавин ажиллаж байна.<br>- Дэд бүтэц /эрчим хүч, авто зам, харилцаа холбоо, тээвэр, газрын тос, хий/<br>- Барилга /барилгын техник, хот төлөвлөлт, өргөх байгууламж, усан хангамж ариутгах татуурга, барилгын материал/ | 100% |
| | | | 9.1.2.хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг хөтлөх; | Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу явуулж нийт 144 зөрчлийн гомдол, мэдээллийн бүртгэлийг хийж, Нийслэлийн Прокурорын газарт niislelprozurchil/@gmail.com цахим хаягаар хүргүүлэн нэгдсэн бүртгэлд бүртгүүлэн ажилласан.<br>Хяналтын улсын байцаагчиийн эрх хэмжээний хүрээнд нийт 709 эрх зүйн баримт бичиг үйлдэж иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад хүргүүлж ажилласан. Үүнд:<br>- зөвлөмж 185,<br>- дүгнэлт 213, | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | | - албан шаардлага 274,<br>- акт 7,<br>- удирдамж 28,<br>- хамтарсан удирдамж 2 | |
| | | | 9.1.5.хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт, техникийн зохицуулалт, стандарт, тэдгээрийг үндэслэн төрийн эрх бүхий байгууллагаас нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон журмыг хэрхэн хэрэгжүүлж байгааг судлан нэгтгэж, холбогдох хууль тогтоомж, шийдвэрийг боловсронгуй болгох саналаа төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх; | Салбарын үйл ажиллагаа, эрх зүйн тогтолцоог сайжруулах, боловсронгуй болгох зорилгоор 12 хуулийн 38 зүйл, заалтад нэмэлт өөрчлөлт оруулах талаар санал боловсруулж Нийслэлийн Засаг даргын Тамгын 2023 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 01/1149 дугаартай албан бичиг хүргүүлсэн. | 100% |
| 6. | 35 | "Барилгын тухай хууль" 2026.02.05 | 35.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга барилгын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:<br>35.1.1.нутаг дэвсгэртээ барилгын салбарт баримтлах төрийн бодлого, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавих; | 2023 онд нийт 2662 объектод хяналт шалгалт хийснээс төлөвлөгөөт бус хяналт шалгалтад 2450, төлөвлөгөөт хяналт шалгалтад 139 иргэн, хуулийн этгээдийг хамруулж, нийт 1846 зөрчлийг илрүүлж, улсын байцаагчийн хүрээнд зөвлөмж 89, албан шаардлага 137, албан даалгавар 106, дүгнэлт 170, акт 10-ыг боловсруулан хүргүүлж, нийт 183 иргэн хуулийн этгээдэд 271.5 сая төгрөгийн торгууль ногдуулж, нийт 920 иргэний өргөдөл гомдол, 1321 хүсэлтийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэн ажилласан байна. | 100% |
| | | | 35.1.2.барилгын үйл ажиллагаанд барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг мөрдүүлэх; | Нийслэлийн хэмжээнд барилга бүтээн байгуулалын ажилд стандарт, нормыг мөрдүүлэх чиглэлээр дараах арга хэмжээ авч ажилласан. Үүнд:<br>- Хотын стандарт, хяналтын газрын даргын 2023 оны "Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай" батлагдсан 5 удирдамжийн дагуу иргэнээс ирүүлсэн 1195 өргөдөл, гомдол, ААНБ-аас ирүүлсэн 1416 хүсэлтийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулж, өргөдөл гомдлын 1147 буюу 96.6%- | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | | г, албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн 1313 буюу 92.7%-ыг бүрэн шийдвэрлэсэн.<br>- Улсын байцаагчийн эрх хэмжээний хүрээнд зөвлөмж 89, албан шаардлага 148, албан даалгавар 106, дүгнэлт 173, акт 10 нийт 526 эрх зүйн баримт хариуг иргэн, ААНБ-д хүргүүлж, зөрчилтэй 122 иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад Зөрчлийн тухай хуулийн заалтуудын дагуу нийт 334 сая төгрөгийн торгууль ногдуулж Улсын /ахлах/ байцаагчийн албан даалгавар хүргүүлж ажилласан байна.<br>- Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтаар Барилга, хот байгууллалтын яамны салбарын хяналтын газраас баталсан 6 удирдамжийн хүрээнд 621 аж ахуйн нэгж, байгууллага, Нийслэлийн Засаг даргын захирамжаар батлагдсан удирдамжийн хүрээнд 421, газрын даргын баталсан 2 удирдамжийн хүрээнд 121 нийт 1163 ААНБ-д урьдчилан сэргийлэх шалгалт хийсэн.<br>Хяналт шалгалтаар илэрсэн 1846 зөрчлийг арилгуулж ажилласан. | |
| | | | 35.1.6.Энэ хуулийн 32.1.5, 33.1.23-т зааснаас бусад барилгын ажлын зөвшөөрөл олгож, барилга байгууламжийг ашиглалтад оруулах; | Нийслэлд шинээр баригдсан нийт 341 барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан. | 100% |
| | | | 35.1.7.барилга байгууламжийн баримт бичгийн шаардлагад нийцээгүй барилга байгууламжийг улсын хяналт хэрэгжүүлэгч байгууллагын ерөнхий байцаагчийн дүгнэлт болон шүүхийн шийдвэрийг үндэслэн албадан буулгах арга хэмжээг авч, холбогдох зардлыг буруутай этгээдээр төлүүлэх; | Нийслэлийн нутаг дэвсгэрт барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээгүйгээр барилга угсралтын ажлыг гүйцэтгэж буй 55 хуулийн этгээдийн 107 блок барилгад зөрчлийг арилгуулахаар Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/288 дугаар захирамж гарч, хэрэгжилтийг хангаж ажилласан. Үүнээс 20 хуулийн этгээдийн 35 барилга байгууламжид салбарын Ерөнхий байцаагчийн дүгнэлт гаргуулахаар хүргүүлж, Барилга, хот байгуулалтын яамны 2023 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 6/3237, 2023 оны 09 дүгээр сарын | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | | 18-ны өдрийн 9/3386 дугаартай албан бичгүүдийн дагуу барилга байгууламжийн чанар, стандартад нийцээгүй 17 барилгад Барилгын техникийн хяналтын улсын /ахлах/ байцаагчийн 17 дүгнэлт гарган салбар яаманд хүргүүлж, Барилга, хот байгуулалтын яамны Салбарын Улсын Ерөнхий байцаагчийн 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 02-00-00/001/01 дугаартай дүгнэлтийг гаргуулан хэрэгжилтийг бүрэн хангуулсан. | |
| **Хэсгийн дундаж хувь: 99.2%** | | | | | |
| **ХОЁР. УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ** | | | | | |
| 7. | 1.3/а/. | Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2019-06-06 Дугаар 2019 №62 | Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн талаар: а/эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрх, агаар, ус, хөрсний бохирдлыг арилгах, хот, суурин газрыг дахин хөгжүүлэх, дэд бүтцийн чиглэлээр баталсан хууль тогтоомжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, зохих арга хэмжээг авах; | 2023 онд Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн хамтарсан А/89, А/296 тушаал, захирамжаар "Улаанбаатар хотын хөрсний чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журам"-ын төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орон ажилласан. Энэхүү журмын төслийг боловсруулахад холбогдох стандартуудын талаарх мэдээллийг нэгтгэн хүргүүлсэн. Тус журмыг Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2023.12.04-ний өдрийн А/615 дугаар тушаалаар баталсан.<br>Мөн тус газраас чиг үүргийн хүрээнд орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас сэргийлэх зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Үүнд:<br>- "Барилгын хог хаягдлын менежмент" хотын стандартын зөвлөмж 144 барилгад, "Аюултай хог хаягдлын менежмент"-н зөвлөмжийг 21, "Нийтийн бие засах газрын төлөвлөлт байгуулалтад тавих техникийн шаардлага" хотын стандартын зөвлөмж 70, барилгын материалын худалдаа, авто үйлчилгээний газарт төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж 23 аж ахуйн нэгжид хог хаягдлын менежмент хотын стандартын зөвлөмжийг тус тус хүргүүлсэн, | 90% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | | - Хотын стандартын сургалтыг нийт 17 удаа 1675 орчим иргэн ААНБ-г хамруулан "Хог хаягдлын менежмент", "Нийтийн бие засах газрын төлөвлөлт байгуулалтад тавих техникийн шаардлага", "Барилгын хог хаягдлын менежмент" сэдвээр зохион байгуулаад байна. | |
| | 1.3/в/. | | Улаанбаатар хотын агаар, ус, хөрсний бохирдлыг арилгах, хот, суурин газрыг дахин хөгжүүлэх, дэд бүтцийн чиглэлээр баталсан хууль тогтоомжийг нэг мөр хэрэгжүүлэх; | Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/146 дугаар захирамжаар "Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орон ажиллаж байна. Уг төлөвлөгөөнд нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд байгаа нүхэн жорлонгийн тоог бууруулж бохирдсон хөрсийг нөхөн сэргээх арга хэмжээг оновчтой тусгах зорилготой. Энэхүү төлөвлөгөөний төсөл нь нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд өргөн барихаар саналын хуудас тойруулах санал авах ажлууд хийгдэж байна. Чиг үүргийн хүрээнд "Нүхэн жорлон, угаадасны нүхний техникийн шаардлага" MNS5924:2015 стандартын судалгааг хийж, шинэчлэн сайжруулах тухай саналыг хүргүүлэхээр бэлтгэсэн. | 90% |
| **Дундаж хувь: 90%** | | | | | |
| **ГУРАВ. ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ** | | | | | |
| 8. | 3.1. | Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх туай 2018-05-23 Дугаар 2018_46 | 3.. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүн шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллгаа, аливаа идэвхи санаачлагыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны | - Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан "Гудамж, зам, барилга байгууламжийн хаягжилт" бүлэгт хамаарах UCS2101A:2023 "Төрийн байгууллагын нэрийн тэмдэг" хотын стандартын шаардлагад төрийн байгууллагын гадна хаягийг үндэсний /уламжлалт монгол бичиг/ бичгээр бичигдсэн байхаар тусгасан.<br>- Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх, түгээн дэлгэрүүлэх чиглэлээр байгууллагын мэдээллийн самбарын зарим хэсгийг монгол, кирилл бичгээр хослуулан бичиж байршуулсан. | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосгай. | - Хэл Иргэншлийн Эрдмийн Хүрээлэн, Нийслэлийн боловсролын газартай хамтран төрийн албан хаагчдад зориулсан Монгол бичгийн сургалтад 2023 оны 11 дүгээр сарын 06-аас 11 дүгээр сарын 17-ны өдрүүдэд 10 албан хаагчийг танхимаар хамруулж Гэрчилгээ олгосон. | |
| 9. | 3.2. | “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” Огноо: 2010.04.14 Дугаар:631 | 1.Жил бүрийн 5, 10 дугаар сарын хоёр дахь долоо хоногийн "Бямба" гарагийг бүх нийтээр мод тарих үндэсний өдөр болгон зарласугай.<br>2.Мод тарих үндэсний өдөр бүх нийтээр мод, бут, сөөг, цэцэг тарих, цаашид арчлан хамгаалах, түүнийгээ амьдралын хэв маяг болгон хэвшүүлэн сурталчилж ажиллахыг Монгол Улсын нийт ард иргэд, айл өрх, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хандивлагч нарт уриалсугай. | Хаврын мод тарих “Ногоон хот – Иргэний оролцоо” 2023 аяны хүрээнд тавдугаар сарын 19-ний өдөр Сонгинохайрхан дүүргийн 24-р хорооны Бумбатын булагт хэмээх газарт 2022 онд тарьсан модны арчилгаа, цэнэг усалгаа, нөхөн тариалалт хийсэн. Намрын мод тарих аяны хүрээнд аравдугаар сарын 15-ны өдөр “Олон Улсын Эко Цэцэрлэгт хүрээлэн” төслийн талбайд 11 ширхэг шар хуайс, 42 ширхэг хайлаас мод суулгаж, цэнэг усалгааг хийсэн. | 100% |
| 10. | 3.3. | “Эзэн Богд Чингис хааны эш хөргийн хүндэтгэн залах тухай” Огноо:2022.07.1 1 Дугаар:159 | Хоёр. Төрийн бүх байгууллага, Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газар, бүх шатны сургалтын байгууллагууд Эзэн Богд Чингис хааны эш хөргийг дээдлэн залсугай. | 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдөр Монгол Улсын нийслэл хот үүсэн байгуулагдсаны түүхт 383 жилийн ойн хүрээнд Эзэн Богд Чингис хааны эш хөргийг Хотын стандарт, хяналтын газрын даргын өрөө болон бусад өрөө танхимд хүндэтгэн залсан. | 100% |
| **Дундаж хувь: 100%** | | | | | |
| **ДӨРӨВ. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ** | | | | | |
| 11. | 4.1. | “Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай” Огноо:2018.05.2 | Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; Үндэсний бичгийн | Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх, түгээн дэлгэрүүлэх чиглэлээр байгууллагын мэдээллийн самбарын зарим хэсгийг монгол, кирилл бичгээр хослуулан бичиж байршуулсан.<br>Хэл Иргэншлийн Эрдмийн Хүрээлэн, Нийслэлийн боловсролын газартай хамтран төрийн албан хаагчдад зориулсан Монгол бичгийн сургалтад 10 | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | 3 Дугаар:2018_463 . | хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай. 4.Энэхүү зарлигт дурдсан ажлуудад болон монгол хэл, бичиг үсгээ сурч судлах, өвлөх, өвлүүлэх, эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх талаар идэвх санаачилга гарган ажиллахыг иргэд, олон нийт, эрдэмтэн судлаачид, шинжлэх ухааны ба хэвлэл мэдээллийн байгууллага, төрийн ба төрийн бус байгууллагуудад уриалсугай. | албан хаагчийг 2023 оны 11 дүгээр сарын 06-аас 11 дүгээр сарын 17-ны өдрүүдэд танхимаар хамруулж Гэрчилгээ олгосон. | |
| 12. | 4.2. | “Дүрэм батлах тухай” Огноо:2019.01.2 3 Дугаар:2019_33 | 2.Байгууллагын дотоод журмыг энэ тогтоолоор баталсан дүрэмд нийцүүлэн баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг төсвийн шууд захирагч нарт даалгасугай. | Шинээр батлагдсан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-д нийцүүлэн байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг шинэчлэн боловсруулж газрын даргын 2023 оны А/56 дугаар тушаалаар батлуулсан. | 100% |
| 13. | 4.3. | Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2018-08-22 Дугаар 2018_258 | 1.. Дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарт үүрэг болгосугай: 1.1. харьяа байгууллага болон салбар, нэгжид сахилга, дэг журмыг сахиулах тодорхой арга хэмжээ авч, төрийн албаны хууль тогтоомж, | Төрийн албаны тухай хууль, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг мөрдөж ажиллаагүй, ёс зүй, сахилга хариуцлагын зөрчил гаргасан 3 албан хаагчид Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.2, 48.1.3 дахь заалтын хүрээнд сахилгын шийтгэл ногдуулж, шийдвэрийг танилцуулсан. | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | холбогдох дүрэм, журмыг зөрчсөн төрийн албан хаагчид хариуцлага тооцож тухай бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнаж байх; | | |
| | | | 1.2. иргэдийг ялгаварлан гадуурхахгүй ижил тэгш, зөв шударга харьцаж, төрийн байгууллагад иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулж, хугацаа хэтэрсэн өргөдөл, гомдлыг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний өдөрт багтаан шийдвэрлэж, хариуг өгөх, цаашид өргөдөл, гомдлыг хугацаанд нь бодитой шийдвэрлэж хэвшүүлэх; | Тус газарт 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар иргэд, ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол нийт 1943 өргөдөл бүртгэгдэн ирсэнээс судлагдаж байгаа 72, хугацаандаа шийдвэрлэсэн 1851, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 20 байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн үед зөрчил гаргахгүйн тулд албан хаагчидтай цахимаар /ERP, вайбер/ болон утсаар, биечлэн уулзаж өргөдлийн хугацаа дөхсөн байгааг мэдэгдэн сунгуулах болон шийдвэрлэхийг сануулан ажиллаж байна. | 100% |
| | | | 1.3. төрийн албан хаагчдын ажлын байрны шинжилгээ хийж, шинжилгээний дүнд тулгуурлан байгууллагын чиг үүргийн давхардал, хийдлийг арилгаж, ажлын бүтээмж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах; | Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 417, 469 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар татан буугдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” А/1649, 2023 оны А/304 дүгээр захирамжаар байгууллагын бүтэц, орон тоонд өөрчлөлт орж барилга, дэд бүтцийн төрийн хяналтын чиг үүрэг шилжин ирсэн. Энэ хүрээнд газрын даргын 2023 оны А/01, А/05 дугаар тушаалаар Албан тушаалын тодорхойлолт боловсруулах ажлын хэсгийг байгуулж, төрийн захиргааны 44, өөрчлөн батлуулах 2, нийт 46 албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн “Зөвшөөрөл олгох тухай” 354, 355 тогтоолоор батлах зөвшөөрөл олгогдож, газрын даргын 2023 оны А/44, А/45 дугаар тушаалаар баталсан.<br>Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1218 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн хүрээнд | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | | 2023 оны 10 дугаар сарын 21, 22-ны өдрүүдэд тус газрын дарга, холбогдох албан хаагчид ажиллан Хотын хөгжлийн индексийн 186 үзүүлэлттэй уялдуулан болон байгууллагын чиг үүргийн уялдаанд дүн шинжилгээ хийж ажлын хэсэгт өгсөн. 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр байгууллагын бүтэц чиг үүргийн оновчтой болгох саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргад танилцуулав. | |
| | | | 1.4. төрийн жинхэнэ албан тушаалд сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллага болон төрийн холбогдох байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр шалгаруулж нөхөн томилох замаар төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх; | Монгол улсын Төрийн албаны тухай хууль болон Монгол улсын Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоол, 2023 онд төрийн захиргааны албан тушаалын сул орон тоог 6 удаа нээлттэй зарлаж, нутгийн захиргааны байгууллага хооронд зарлан, зохион байгуулсаны үр дүнд сонгон шалгаруулалтаар удирдах, гүйцэтгэх албан тушаалын тусгай шалгалтыг 18 албан хаагч өгч тэнцсэний дагуу албан тушаалд нь жинхлэн томилж ажиллуулсан. | 100% |
| | | | 1.5. төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалд албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байгаа удирдах албан тушаалтнуудын сонгон шалгаруулалтын захиалгыг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн дотор Төрийн албаны зөвлөлд хүргүүлж, сонгон шалгаруулалтын дагуу удирдах албан тушаалтныг томилох; | -Байгууллагын бүтэц, орон тоо шинэчлэн батлагдсаны дагуу 3 удирдах албан тушаал шинээр бий болсон. Шинээр бий болсон албан тушаалын албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны төв, салбар зөвлөлөөр шинэчлэн батлуулах, хянуулан ажиллах хугацаанд удирдах албан тушаалтны албан үүргийг Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.3 дахь заалтын дагуу тухайн төрлийн албан тушаалын чиг үүрэгт нь хамгийн ойр хамааралтай 3 албан хаагчаар түр орлон гүйцэтгүүлэн ажиллаж байна.<br>-Төрийн албаны тухай хууль болон Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийн хүрээнд удирдах, гүйцэтгэх, туслах албан тушаалын албан үүргийг төрийн жинхэнэ 10 албан хаагчаар түр орлон гүйцэтгүүлсэн. | 100% |
| | | | 1.6. төрийн жинхэнэ албан хаагч жирэмсний болон амаржсны амралттай байгаа, эсхүл 3 сараас | Тус газарт Хөдөлмөрийн тухай хуулийн 137, 139 дүгээр зүйлийн хүрээнд жирэмсний болон хүүхэд асрах чөлөөтэй 4 албан хаагч байна. Төрийн албаны | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | дээш хугацааны сургалтад хамрагдаж сул орон тоо гарснаас бусад тохиолдолд төрийн албаны сул орон тоонд гэрээт ажилтан томилохгүй байх зарчим баримталж, төрийн байгууллагад албан ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн богино хугацаагаар ажиллуулахаас бусад тохиолдолд гэрээт ажилтан ажиллуулахгүй байх; | зөвлөлийн 2023 оны 15 дугаар хуралдааны тэмдэглэлээр баталсан зөвлөмжийн дагуу жирэмсний болон амарсаны амралтай, хүүхэд асрах чөлөөтэй байгаа албан хаагчийн албан тушаалд төрийн албаны ерөнхий шалгалт өгч тэнцсэн нөөцөд байгаа иргэдийг гэрээгээр авч ажиллуулахаар төлөвлөж байна. | |
| | | | 1.7. төрийн албан хаагч албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох, төрийн байгууллагын байр, ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг байгууллагын дотоод журамд тусган хориглож, зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох; | Газрын даргын 2023 оны А/56 дугаар тушаалаар шинэчлэн боловсруулсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 3.3.9 дэх хэсэгт ажлын байранд архидан согтуурах, мансууруулах бодис хэрэглэхийг хориглох заалтыг тусган журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна. 2023 онд байдлаар байгууллагын хэмжээнд тус заалттай холбоотой зөрчил гараагүй байна. | 100% |
| | | | 1.8. төрийн албан хаагчдын үйлдсэн гэмт хэрэг, гаргасан зөрчил, сахилга, ёс зүйн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тогтоон, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах; | Газрын даргын 2023 оны А/06 дугаар тушаалаар Ёс зүйн зөвлөлийг 6 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулж ёс зүйн дотоод дүрмийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, албан хаагчдын ёс зүйн нийтлэг хэм хэмжээг мөрдүүлэх, түүнийг зөрчсөн тухай иргэн, хуулийн этгээдийн гомдол мэдээллийг хянах, зөрчил гаргасан эсэх, хариуцлага хүлээлгэх асуудлаар холбогдох шийдвэрийг гарган ажиллаж байн.<br>Төрийн албаны тухай хууль, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм, | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | | байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг мөрдөж ажиллаагүй, ёс зүй, сахилга хариуцлагын зөрчил гаргасан 3 албан хаагчид Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.2, 48.1.3 дахь заалтын хүрээнд сахилгын шийтгэл ногдуулж, шийдвэрийг танилцуулсан. | |
| | | | 1.10. ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг таслан зогсоож, ийм үйлдэл гаргасан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын талаар байгууллагын дотоод журамд тусган мөрдүүлж,ээрэг уур амьсгалтай, сэтгэл зүйн дарамтгүй ажиллах орчныг бүрдүүлэх арга хэмжээ авах; | Байгуулагын ёс зүйн дотоод дүрэмд ажлын байран дахь хууль бус дарамт шахалт, үйлдлийг хориглон албан хаагчдын хариуцлага ёс зүйг дээшлүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай заалтыг тусган хамт олныг ээрэг уур амьсгалтай, сэтгэл зүйн дарамтгүй орчинд ажиллах нөхцлийг бүрдүүлэн дүрмийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллаж байна. | 100% |
| | | | 3.. Төрийн албаны соёл, дэг журмыг сахиулах, ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор гэнэтийн болон төлөвлөгөөт хяналт шалгалтыг холбогдох байгууллагатай хамтран төрийн байгууллагуудад тогтмол зохион байгуулж байхыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатарт, өөрийн эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын агентлаг, төрийн бусад байгууллагад хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой | Газрын даргын 2023 оны “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах тухай” А/24, А/52 тушаалаар газрын нийт 7 хэлтсийн үйл ажиллагаанд батлагдсан удирдамж, хуваарийн дагуу дотоод хяналт шалгалтыг зохион байгуулсан. Хяналт шалгалтын удирдамжид албан хаагчдын ажлын цаг ашиглалт, сахилга хариуцлага, хөдөлмөрийн дотоод дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт тавьж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар санал, зөвлөмжийг хүргүүлэн ажилласан. | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарт тус тус даалгасугай. | | |
| 14. | 4.4. | “Төрийн албаны цалингийн нэгдсэн систем нэвтрүүлэх тухай” Огноо:2020.05.06 Дугаар 2020_163 | 3.Төрийн албан хаагчийн цалин хөлсний бүрэлдэхүүн, албан тушаалын ангилал, шатлал, зэрэглэл болон цалин хөлс тооцоолоход шаардагдах бусад мэдээлэлд өөрчлөлт орсон тухай бүрт өөрчлөлтийг хүний нөөцийн удирдлагын мэдээллийн системд үнэн зөв байдлаар оруулж, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангаж ажиллахыг бүх шатны төсвийн захирагч нарт даалгасугай. | Төрийн албаны Хүний нөөцийн удирдлагын нэгдсэн тогтолцоо системийг шинэчлэн нэвтрүүлснээр уг системд байгууллагын албан хаагчдын мэдээллийг бүрэн оруулж ажиллаж байна. 2023 онд ажлаас чөлөөлөгдсөн 18, төрийн захиргааны байгууллага хооронд шилжин ажилласан 6, сэлгэн томилсон 1, албан тушаалд шинээр томилогдсон 21, түр орлон гүйцэтгүүлсэн болон ажил хавсран гүйцэтгүүлсэн 10, жирэмсний болон хүүхэд асрах чөлөөтэй 4, тэтгэвэр тогтоолгох насанд хүрч чөлөөлөгдсөн 3 албан хаагчийн мэдээллийг системд тухай бүр оруулан өөрчлөлтийг хийж ажилласан. Мөн Засгийн газрын 2022 оны 487 дугаар тогтоолын дагуу албан хаагчдын албан тушаалын зэрэглэл, шатлал өөрчлөгдснийг тухай бүрт оруулан ажиллаж, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангаж ажиллаж байна. | 100% |
| 15. | 4.5. | “Журам шинэчлэн батлах тухай” Огноо: 2020.12.09 Дугаар:206 | Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмыг шинэчлэн батлах тухай” | Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын дагуу бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд улирал, хагас бүтэн жилээр хяналт шинжилгээ, үнэлгээ хийж тайлант хугацаанд Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тайлагнан ажилласан. | 100% |
| 16. | 4.6. | “Журам шинэчлэн батлах тухай” (Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам) | 1.”Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай. | Засгийн газрын 2021 оны 226 дугаар тогтоолоор батлагдсан “Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам”, “Баримт бичгийн стандарт” MNS 5140-2:2021-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд байгууллагын тамга, тэмдэг, архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд ашигладаг баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудсыг журам стандартад нийцүүлсэн. | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | Огноо: 2021.08.04 Дугаар: 226 | | Тус журмын дагуу газрын даргын 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн “Тамга түших хариуцлагатай албан тушаалтан томилох тухай” А/03 дугаар тушаалаар баталгаажуулан үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн. Албан хэрэгцээнд албан бичиг болон улсын /ахлах/ байцаагчдын эрх зүйн баримт бичгийн хэвлэмэл хуудсыг шаардлагатай тоогоор хэвлүүлж байгууллагын хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна | |
| 17. | 4.7. | “Жагсаалт батлах тухай” Огноо: 2021.12.01 Дугаар: 2021_359 | 4.Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр шуурхай зохион байгуулж, үр дүнг тухай бүр цахим системд байршуулж ажиллахыг Төсвийн ерөнхийлөн захирагч, Төрийн худалдан авах ажиллагааны газар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайханд тус тус даалгасугай. | Газрын 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 8 бараа ажил, үйлчилгээг худалдан авахаар боловсруулан батлуулж Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системээр зарлан үр дүн болон явцын мэдээг тухай бүр оруулан ажиллаж байна.<br>Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу шууд худалдан авалт болон тендер шалгаруулалтыг зохион байгуулан ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан. Үүнд.<br>1. Авто зам, замын байгууламжийн 2 хотын стандартын төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээ<br>2. Үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, үнэлгээний хөтөлбөр, арга зүй боловсруулах судалгаа<br>3. Хотын стандартыг сурчлан таниулах контент багц 1 боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээ<br>4. Хотын стандартыг сурчлан таниулах контент багц 2 боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээ<br>5. Хотын стандартыг сурчлан таниулах контент багц 3 боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээ<br>6. Хэвлэлийн ажил гүйцэтгэх гэрээ | 100% |
| 18. | 4.8. | Дүрэм шинэчлэн батлах тухай 2021-07-20 | 2. “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийг | Барилга байгууламж ашиглалтад оруулах дүрмийн дагуу Нийслэлд шинээр баригдсан 341 барилга байгууламж, 635 гадна цахилгаан хангамж, | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | Дугаар 2021_212 | хавсралт ёсоор шинэчлэн баталсугай. Шинэчлэн батлагдсан дүрмийн хэрэгжилтийг улсын хэмжээнд хангуулж ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатарт, аймаг, нийслэлийн хэмжээнд хангуулж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай | гэрэлтүүлэг, улс, нийслэл, дүүргийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 340 барилга байгууламжийн их засвар, шинэчлэлт, тохижилтын ажлыг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг зохион байгуулж хэрэгжилтийг хангуулж ажилласан. | |
| 19. | 4.9. | “Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвийн үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай” Огноо: 2022.05.11 Дугаар: 187 | 1.Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвийн үйл ажиллагааг эрчимжүүлэх дараахь арга хэмжээ авахыг дор дурдсан албан тушаалтанд даалгасугай: 1.1.Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд ирүүлсэн өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах өргөдөл, гомлын шуурхай шийдвэрлэж, салбарын бодлого, шийдвэрт тусгах боломжтой ажил хэрэгч саналыг судлан тусгаж, энэ тухай байгууллагын цахим хуудсанд сар бүр мэдээллэж ажиллахыг бүх шатны төсвийн захирагч нарт... | Тус газарт 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар 11- 11 төвөөр дамжиж нийт 999 өргөдөл ирсэн. Үүнээс судлагдаж байгаа 30, хугацаандаа шийдвэрлэсэн 969 байна. Өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд, шуурхай шийдвэрлэж ажиллахыг албан хаагчдад үүрэг болгож, хэрэгжилтэд дотоод хяналт тавин ажиллаж, байгууллагын цахим хуудас https://standard.ub.gov.mn/ өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээг тогтмол байршуулж байна. | 90% |
| 20. | 4.10. | Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 2023-06-21 Дугаар 2023_241 | Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. | 2022 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 488 дугаар тогтоолын 5 дахь заалт, Журамд өөрчлөлт оруулах тухай 491 дүгээр тогтоолын дагуу тус газрын албан хаагчдын төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэл, цалингийн хэмжээ, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг газрын даргын 2023 оны А/03, А/17 дугаар тушаалаар батлан батлагдсан төсвийн хүрээнд багтаан олгож байна. | 90% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| 21. | 4.11. | Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай 2023-06-21 Дугаар 2023_240 | "Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт"-ыг 6 дугаар хавсралт ёсоор тус тус шинэчлэн тогтоосугай. Энэ тогтоолыг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй. | Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн доод хэмжээнд өөрчлөлт орсонтой холбогдуулан газрын даргын 2023 оны “Төрийн үйлчилгээний албан тушаалын цалинг шинэчлэн тогтоох тухай” А/45 дугаар тушаалаар батлагдсан цалингийн санд багтаан олгож байна. | 90% |
| 22. | 4.12. | Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай 2023-01-11 Дугаар 2023_79 | 3. Хяналт шалгалтын үйл ажиллагаанд шаардагдах зардлыг 2023 оны батлагдсан төсөвтөө багтаан, шаардлагатай бол зохицуулалт хийн санхүүжүүлж, цаашид холбогдох эх үүсвэрийг жил бүрийн улсын төсвийн төсөлд батлуулж байхыг Засгийн газрын холбогдох гишүүд, Сангийн сайд Б.Жавхлан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | Байгууллагын чиг үүргийн дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаанд шаардлагатай бичиг хэрэг, тээвэр шатахууны зардлыг 2023 оны батлагдсан төсөвт багтаан зохицуулалт хийх замаар санхүүжүүлэн ажиллаж байна.<br>Мөн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны зардал, хохирлын нөхөн төлбөрийн хэмжээг тооцуулах шинжээч (төсөвчин, үнэлгээчин)-ийг ажиллуулахад шаардагдах зардлыг Газрын даргын 2023 оны “Хөрөнгө гаргах тухай” А/54 дүгээр тушаалын дагуу хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 90% |
| 23. | 4.13. | 2023-2024 оныг Авилгатай тэмцэх жил болгон зарлах тухай 2023_49 | 3. Авилгатай тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, бүх талын дэмжлэг үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагын дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. | Авлигатай тэмцэх газрын “110” дугаар утсыг сурталчлах зорилгоор тус газрын Олон нийтийн төвтэй холбогдох QR код, постерийг хийж вэбсайтын нүүр хуудсанд байршуулснаас гадна Засгийн газраас 2023-2024 оныг “Авлигатай тэмцэх жил” болгон зарлаж “Авлигатай тэмцэх таван ажиллагаа”-г хэрэгжүүлж байгаатай холбогдуулан “Шүгэл ажиллагаа”-ны хүрээнд авлигын эсрэг “НЭГДЬЕ” үндэсний хэмжээний нөлөөллийн аян нэгдэхийг сурталчилсан постерыг вэбсайтын нүүр хуудсанд байршуулсан. | 90% |
| **Хэсгийн дундаж хувь: 97.7%** | | | | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| **ТАВ. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ** | | | | | |
| 24. | 5.1. | Ажлын хэсэг байгуулах тухай 2023-04-11 Дугаар_70 | 2.Ажлын хэсгийн ажлын удирдамж, төлөвлөгөө батлан хэрэгжүүлж, “Сэлбэ сэргэлт” төслийг хэрэгжүүлэх газрын хэмжээ, хил заагг, замын чигийг тогтоох асуудлыг 2023 оны II улиралд багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Ажлын хэсэг (Ц.Даваасүрэнд)-т даалгасугай. | Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд газрын дарга С.Төмөрдулам ажиллаж, ажлын хэсгийн 2 удаагийн хуралдаанд оролцсон. Нийслэлийн Зураг төслийн хүрээлэнгээс боловсруулж буй “Сэлбэ сэргэлт” төслийн зураг төсөлд санал тусган ажиллаж байна. | 90% |
| **Хэсгийн дундаж хувь: 90%** | | | | | |
| **ЗУРГАА. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ** | | | | | |
| 25. | 6.1. | 2019 оны 5 дугаар сарын 29-ны өдөр 24 дүгээр тэмдэглэл Дугаар 2019_24 | XX.11. . “Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх Ази, Номхон далайн бүсийн IY конгресс”-ын бэлтгэл ажлын талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br>Үүнтэй холбогдуулан уг конгрессыг Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор зохион байгуулах ажлын хүрээнд дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд даалгав:<br>1. Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:<br>1.4.барилга, байгууламжийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй болгох. | Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагаанд Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоол, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай” хуулийн 9.4 дэх хэсэгт заасны дагуу 2023 оны хагас жилийн байдлаар төрийн болон нийгмийн үйлчилгээний 341 барилгыг хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчны шаардлага MNS6055:2009 болон бусад холбогдох норм, дүрэм, стандартыг хангасан эсэх, саадгүй байдал, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хүртээмжтэй, стандартын шаардлагын дагуу болгох үүрэг даалгавар өгч, биелэлтийг хянаж байнгын ашиглалтад оруулж дүгнэлтийг баталгаажуулсан. | 100% |
| 26. | 6.2. | 2021 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн хуралдааны 34 | 2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох тэгш эрхийг хамгаалж, холбогдох хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг | 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдөр Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 42 дугаар тогтоолоор “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй дэд бүтэц” бүлгийн дараах дараах хотын стандартыг | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | дүгээр тэмдэглэл 2021-06-08 Дугаар 2021_34 | эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэртээ хангуулах, хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | баталж 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдүүлэхээр тогтоосон. Үүнд:<br>1. UCS 1001A “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд дэд бүтцийн хүртээмжийг дээшлүүлэх арга зүйн удирдамж”,<br>2. UCS 1001C “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй дэд бүтцийн зураг төсөл".<br>Эдгээр хотын стандарт нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн асуудлаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, нийслэлд хэрэгжүүлэх хот байгуулалт, хот нийтийн аж ахуйн бүтээн байгуулалт, тохижилт, засвар үйлчилгээний ажил, үйлчилгээг төлөвлөх, удирдан зохион байгуулах, гүйцэтгэх, хяналт тавих, орон сууц болон олон нийтийн барилгын гадна орчин, дотоод орон зайг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэйгээр төлөвлөхөд дагаж мөрдөх юм. | |
| | | | 4. Нийслэлийн нийтийн тээврийн парк шинэчлэлийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүн тээвэрлэхэд зориулагдсан тээврийн хэрэгсэл худалдан авах чиглэл баримталж ажиллахыг нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазарт; | Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022.03.24-ний өдрийн 18-26 дугаар тогтоолоор батлагдсан 9 бүлгийн 38 хотын стандартад Зорчигч тээврийн үйлчилгээ бүлгийн дараах 5 хотын стандартыг батлуулж, 2022 оны 10 дугаар 01-ний өдрөөс эхлэн мөрдүүлэхээр тогтоосон. Үүнд:<br>1. UCS1601B:2022 “Нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолд тавигдах ерөнхий шаардлага“;<br>2. UCS1602B:2022 “Такси зогсоолд тавигдах ерөнхий шаардлага”;<br>3. UCS1603B:2022 “Нийтийн тээврийн үйлчилгээ, тээврийн үйлчилгээ, тээврийн хэрэгсэлд тавигдах ерөнхий шаардлага”;<br>4. UCS1604B:2022 “Хүүхдийн автобусанд тавигдах ерөнхий шаардлага”;<br>5. “UCS1605B:2022 “Такси үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлага”.<br>Эдгээр хотын стандартад хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тээвэрлэхэд зориулагдсан байх шаардлагыг | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | | тусгасан. 2023 онд нийтийн тээврийн парк шинэчлэлийн хүрээнд нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн нийтийн тээврийн хэрэгслийг хүлээн авах ажлын хэсэгт орж ажиллан 224 нийтийн тээврийн автобус, 50 хүүхдийн автобусыг хотын стандартын шаардлагад нийцүүлэн ашиглалтад хүлээн авсан. | |
| 27. | 6.3. | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл Огноо: 2021.10.13 Дугаар: 2021_55 | XY.13.6."Худалдан авах ажиллагааны цахим систем"-д худалдан авах ажиллагааны үр дүн, гэрээ, гэрээний биелэлтийг тухай бүр байршуулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэхийг худалдан авах ажиллагаа зохион байгуулдаг бүх байгууллагын удирдлагад; | Газрын 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 8 бараа ажил, үйлчилгээг худалдан авахаар боловсруулан батлуулж худалдан авах ажиллагааны tender.gov.mn цахим системд нийтэлсэн. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу шууд худалдан авалт болон тендер шалгаруулалтыг зохион байгуулан ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан. Үүнд.<br>1. Авто зам, замын байгууламжийн 2 хотын стандартын төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээ<br>2. Үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, үнэлгээний хөтөлбөр, арга зүй боловсруулах судалгаа<br>3. Хотын стандартыг сурчлан таниулах контент багц 1 боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээ<br>4. Хотын стандартыг сурчлан таниулах контент багц 2 боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээ<br>5. Хотын стандартыг сурчлан таниулах контент багц 3 боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээ<br>6. Хэвлэлийн ажил гүйцэтгэх гэрээ | 90% |
| 45. | | ”Хотын стандартыг батлах тухай“ хэлэлцээд 2023.03.30 №05 | 1.3.2. Нийслэлийн ИТХ-аар цаашид батлуулахаар өргөн барих хотын стандартыг төслийг танилцуулахдаа өмнөх Хурлуудаар батлагдсан хотын стандартын хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар заавал мэдээлж танилцуулж байх; | Батлагдсан 9 бүлгийн 38 хотын стандартыг нийслэлийн хэмжээнд дагаж мөрдүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Хотын стандартыг мөрдүүлэх бэлтгэл арга хэмжээний төлөвлөгөөг батлах тухай” А/851, 2023 оны “Хууль, норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/242 дугаар захирамжаар хэрэгжүүлсэн ажлын үр дүнг нэгтгэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт танилцуулсан. Гуравдугаар ээлжийн хотын стандартыг батлуулахдаа хотын стандартын хэрэгжилт, үр дүнг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдын Хуралд танилцуулахаар төлөвлөн ажиллаж байна. | 90% |
| | | | 1.3.3.Хурлаар батлагдаж буй хотын стандартыг хэрэгжүүлэхэд цахим платформыг ашиглах, нэвтрүүлэх чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран ажиллах, стандартыг мөрдөж эхлэхээс өмнөх хугацаанд сургалт сурталчилгааны ажлыг үе шаттайгаар дүүргүүдийн ЗДТГ-тай хамтран зохион байгуулж ажиллахыг Хотын стандарт хяналт зохицуулалтын газарт чиглэл болгох; | Батлагдсан 9 бүлгийн 38 хотын стандартыг сурталчлан таниулах видео контент, ярилцлага, зурагт хуудас боловсруулах ажилд зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч байгууллагыг сонгон шалгаруулж хамтран ажиллаж байна. Цаашид уг контент хотын стандартын сургалтын үйл ажиллагаанд ашиглагдах ач холбогдолтой.<br>Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Хууль, норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/242 дугаар захирамжийн хүрээнд 9 дүүргийн ЗДТГ-тай хамтран батлагдсан хотын стандартын сэдэвчилсэн сургалтыг 13 удаа зохион байгуулан нийт 1506 албан хаагч, аж ахуйн нэгж байгууллагын төлөөллийг хамруулсан. | 90% |
| | | | 1.4.1.Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага бүр ажил үүргийн чиглэлээр холбоотой хотын стандартын төсөлд саналаа өгөх, батлагдсан стандартын хэрэгжилтийг хангуулах, мөрдүүлж | - Хотын стандартын хэрэгжилтийг нэгдсэн зохион байгуулалттай болгох, хотын стандартын тогтолцоог хөгжүүлэх зорилгоор “Хотын стандартыг батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах журам”-ын төсөл боловсруулсан. Журмын төсөлд Захиргааны ерөнхий хуулийн 62.1-д заасны дагуу байгууллагын веб хуудас, Ulaanbaatar.mn, erp.ulaanbaatar.mn зэрэг цахим | 90% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | ажиллах, стандартын хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт тавих; | хуудсанд байрлуулж, нийт 21 төрийн байгууллага, 764 иргэн, ААНБ-аас ирүүлсэн саналыг хүлээж авч тусгасан. Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанд танилцуулж Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барихаар шийдвэрлэсэн. Одоогоор иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудаас дахин санал авч төслийг хянан тохиолдуулах ажил хийгдэж байна.<br>- Хотын стандартыг мөрдүүлэх арга хэмжээний хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/242 дугаар захирамжаар удирдамж, нэгдсэн төлөвлөгөө батлуулсан. Төлөвлөгөөнд хотын стандартыг сурталчлах, зөвлөмж арга зүйгээр хангах, судалгаа хийх, хяналт шалгалт гэсэн үндсэн 4 чиглэлээр нийт 126 арга хэмжээ тусган хэрэгжилтийг хангуулж ажилласан. | |
| 46. | | | 1.4.2.Батлагдсан стандартыг хэрэгжүүлэх явцад нэмж тусгах болон өөрчлөх, засаж сайжруулах талаарх санал хүсэлтээ холбогдох мэргэжлийн байгууллагад мэдээлэх, хамтран ажиллах | Нийслэлийн Нийтийн тээврийн газар болон Шилэн хаалга, цонх үйлдвэрлэгчдийн холбооноос холбогдох хотын стандартад нэмж тусгах санал, хүсэлт ирүүлсэн бөгөөд хүсэлтийг Нийслэлийн Засаг дарга, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт уламжилсан. “Зорчигч тээврийн үйлчилгээ” бүлгийн 2 төрлийн батлагдсан хотын стандартад нэмэлт өөрчлөлт оруулахаар тогтоолын төслийг боловсруулан Нийслэлийн Засаг даргын эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан орлогч П.Сайнзоригт танилцуулсан | 90% |
| **Хэсгийн дундаж хувь: 90%** | | | | | |
| **АРАВ. НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ** | | | | | |
| 47. | | “Хууль, норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах талаар авах зарим арга | 1.Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилтын хүрээнд хууль, стандарт, нормын хэрэгжилтийг хангуулах, хяналт шалгалт зохион байгуулах ажлын удирдамжийг 1 дүгээр, нэгдсэн | Захирамжийн нэгдсэн төлөвлөгөөнд 4 бүлгийн 126 арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан. Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд дэд ажлын хэсэг байгуулагдан 1821 иргэн аж ахуйн нэгжид 18 удаагийн сургалт, Хяналт шалгалтыг нийт 698 аанб, зөвлөн туслах чиглэлээр 132 байршилд ажилласан байна. | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | хэмжээний тухай" 2023.03.16 А/242 | төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус батлагсугай.<br>2.Батлагдсан удирдамж, төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг холбогдох нутгийн захиргааны болон бусад байгууллагуудад, удирдамжид заасны дагуу хамтран ажиллахыг дүүргүүдийн Засаг дарга нарт, хэрэгжилт, үр дүнг иргэд, олон нийтэд сурталчлан таниулахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэлтэй, олон нийттэй харилцах хэлтэс (Г.Хонгорзул)-т тус тус даалгасугай. | Мөн олон нийтэд сурталчилан таниулах чиглэлээр хэвлэл мэдээллийн хэрэгслээр 17 удаа мэдээлэл бэлтгэн хүргэсэн.<br>Нутгийн захиргааны байгууллагуудын хувьд хариуцсан чиг үүргийн хүрээнд сургалт мэдээллээр хангах, төрийн болон төрийн бус байгууллагуудтай уулзалт зохион байгуулах, зөвлөн туслах, мэдээлэл арга зүйгээр хангах зохион байгуулалтын арга хэмжээг авч ажилласан байна.<br>Нутгийн захиргааны 29 байгууллагаас ирүүлсэн төлөвлөгөөний биелэлт, ажлын тайланг нэгтгэн боловсруулж хэрэгжүүлсэн ажлын явц, үр дүнд дүгнэлт хийхэд төлөвлөгөөний хэрэгжилт дунджаар 86,4 хувийн биелэлттэй үнэлэгдэж 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 01/1534 дүгээр албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 01/1581 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | |
| 48. | | Ажлын хэсэг байгуулах тухай 2023.03.27 А/288 | Нийслэлийн нутаг дэвсгэрт зохих зөвшөөрөлгүй барилгын ажил гүйцэтгэж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх, дүгнэлт гарган цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор байгуулсугай. | Нийслэлийн нутаг дэвсгэрт зохих зөвшөөрөлгүй барилгын ажил гүйцэтгэж буй 55 иргэн, хуулийн этгээдийн хяналт шалгалтыг хийж, үр дүнг Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 11 дугаар хуралдаанд дахин хэлэлцүүлснээр 20 хуулийн этгээдийн 35 барилга байгууламжийг салбарын Ерөнхий байцаагчийн дүгнэлт гаргуулахаар хүргүүлж, Барилга, хот байгуулалтын яамны 2023 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 6/3237, 2023 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 9/3386 дугаартай албан бичгүүдийн дагуу барилга байгууламжийн чанар, стандартад нийцээгүй 17 барилгад Барилгын техникийн хяналтын улсын /ахлах/ байцаагчийн 17 ширхэг дүгнэлтийг гарган салбар яаманд хүргүүлж, Барилга, хот байгуулалтын яамны Салбарын Улсын Ерөнхий байцаагчийн 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 02-00-00/001/01 | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | | дугаартай дүгнэлтийг гаргуулан хэрэгжилтийг бүрэн хангуулсан. | |
| 49. | | Хууль, журмын хэрэгжилтийг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2023 оны 04 сарын 18-ны өдөр Дугаар А/394 | 1.Нийслэлийн оршин суугч, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, газар ашиглалтыг сайжруулах, авто замын түгжрэлийг бууруулах, явган хүний зам, ногоон байгууламж, нийтийн эзэмшлийн зам, талбайг нэмэгдүүлэх зорилгоор хууль, журам зөрчсөн, стандартын бус хашаа, хайс барьсан газруудын зөрчлийг арилгах, газар чөлөөлөх байршлыг 1 дүгээр, UCS1410B:2022 Хашаа, хайс, хашлаганд тавих ерөнхий шаардлага-Хотын стандартад нийцүүлэх хашаа, хайс, хашлаганы жагсаалтыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус батлсугай | Баянгол, Баянзүрх, Сүхбаатар дүүргийн нийт 46 (Баянгол дүүрэг-38, Баянзүрх дүүрэг-4, Сүхбаатар дүүрэг-4) байршилд хашаа, хайс хашлагад стандарт мөрдүүлэхээр төлөвлөснөөс 34 байршилд стандартад нийцүүлсэн. Бусад 12 байршилд стандартын дагуу засаж шинэчлэх талаар холбогдох аж ахуйн нэгж байгууллагуудад зөвлөмж, мэдэгдэл хүргүүлсэн. | 70% |
| 50. | | Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх тухай 2023 оны 04 сарын 17-ны өдөр Дугаар А/386 | 1.Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын 2023 оны БАЗГ2023/051 дугээр "Барилгын ажпын зөвшөөрлийн гэрчилгээ", Нийслэлийн ерөнхий архитекторын 2020 оны ГБМЗХ2020/17-053 дугаар "Архитектор төлөвлөлтийн даалгавар"-ын биелэлтийг тухайн барилгын ажилтай холбогдуулан Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хороо, Юнескогийн гудамжинд байрлах "Ойн гудамж" СӨХ болон оршин суугч, иргэдийн гаргасан гомдлыг эцэслэн шийдвэрлэх хүртэл хугацаанд түдгэлзүүлсүгэй. | Захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Хууль эрх зүйн асуудал хариуцсан Ахлах зөвлөх Д.Мөнх-Эрдэнэ, Хотын стандарт, хяналтын газрын Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч З.Ганбат, улсын байцаагч Б.Шинэжаргал, Сүхбаатар дүүргийн Цагдаагийн 1 дүгээр хэлтсийн холбогдох албан хаагчид ажиллаж, захирамжийг танилцуулан үйл ажиллагааг түр зогсоож, лац тавьж битүүмжилсэн. Улмаар НЗД-ын 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн А/512 дугаартай захирамж гарч зөвшөөрлийн гэрчилгээг хүчингүй болгосон. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| 51. | | Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх тухай 2023 оны 05 сарын 22-ны өдөр Дугаар А/517 | 1.Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын 2022 оны 0010540/134/2022 дугаар "Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ", Нийслэлийн ерөнхий архитекторын 2020 оны ГБМЗХ2020/27-010 дугаар "Архитектор төлөвлөлтийн даалгавар"-ын биелэлтийг тухайн барилгын ажилтай холбогдуулан Баянзүрх дүүргийн 18 дугаар хорооны оршин суугч, иргэдийн гаргасан гомдлыг эцэслэн шийдвэрлэх хүртэл хугацаанд түдгэлзүүлсүгэй.<br>2.Энэ захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Нийслэлийн Ерөнхий архитектор бөгөөд Хот байгуулалт, хөгжлийн газрын дарга Б.Тулгад, холбогдох барилга угсралтын үйл ажиллагааг зогсоохыг Нийслэлийн Хотын стандарт, хяналтын газар (С.Төмөрдулам)-т, орчны аюулгүй байдал, хэв журам сахиулж, дэмжлэг үзүүлж ажиллахыг Нийслэлийн Цагдаагийн удирдах газар (О.Ганбат)-т тус тус үүрэг болгосугай. | Захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2023 оны 05 дугаар сарын 22-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Хууль эрх зүйн асуудал хариуцсан Ахлах зөвлөх Д.Мөнх-Эрдэнэ, НЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн В.Баттулга, Хотын стандарт, хяналтын газрын Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч З.Ганбат, улсын байцаагч Т.Батсүх нар очиж лацдан үйл ажиллагааг түр зогсоож, баримт бичгийг татан авч шалган Баянзүрх дүүргийн 18 дугаар хороо, орон сууцны 14 дүгээр барилгын оршин суугч О.Догмид, С.Номингэрэл, Ж.Нарантуяа, Ш.Үдэнбор, Р.Гэрэлсүрэн нарын иргэдэд хандан норм стандарт хангагдахгүй байгаа талаар 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 01/570 дугаартай албан бичгээр хариуг хүргүүлж, хувийг НЗДТГ-т хүргүүлсэн | 100 |
| 52. | | Үндэсний их баяр наадмын өдрүүдэд авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай 2023 оны 07 сарын 10-ны | 2.Баяр, амралтын өдрүүдэд эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, иргэдийн амгалан тайван байдал алдагдуулахгүй байхад хяналт тавьж ажиллахыг ....... Нийслэлийн Хотын стандарт, | Баяр наадмын амралтын өдрүүдэд нийслэлийн Шуурхайн мэдээллийн төв 310005 дугаарын утсанд иргэдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу зөвшөөрөлгүй барилга угсралтын ажил гүйцэтгэж буй дараах 2 аж ахуйн нэгжид хяналт шалгалт хийж, холбогдох арга хэмжээ авч ажилласан. Үүнд:<br>- Баянзүрх дүүргийн 25 дугаар хороо, Гёте бүрэн дунд сургуулийн өргөтгөлийн барилгад хяналт шалгалт | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | өдөр Дугаар А/805 | хяналтын газар (С.Төмөрдулам)-т тус тус үүрэг болгосугай. | хийхэд эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй барилга угсралтын ажил эхлүүлсэн байх тул Зөрчлийн тухай хуулийн 12.1 дүгээр зүйлийн 2 дах хэсгийн 2.1 дэх заалтад зааснаар торгуулийн арга хэмжээ авч, барилга угсралтын ажлыг зогсоох тухай эрх бүхий албан тушаалтны албан даалгавар хүргүүлсэн.<br>- Баянгол дүүргийн 1 дүгээр хороо, Алтай хотхон 27-р байрны 160, 75 тоот айлууд барилгын дээвэр дээр зөвшөөрөлгүй, ажлын зураггүй өргөтгөлийн ажил гүйцэтгэж байсныг тогтоон ажлыг зогсоосон. Мөн тухайн барилгын дээвэр рүү иргэд чөлөөтэй нэвтрэх нөхцөл байдал үүссэн байх тул орц гарцыг битүүмжлүүлэх арга хэмжээ авсан. | |
| 53. | | Ажлын хэсэг байгуулах тухай 2023.07.18 А/815 | 1.Бизнес эрхлэгчдийг дэмжих зорилтын хүрээнд “Ногоон бүс”-д хамрагдах шалгуур үзүүлэлт, үнэлгээний аргачлалыг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг хавсралтаар байгуулсугай. | Ажлын хэсгийн хүрээнд худалдаа, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдийг дэмжих “Ногоон бүс” буюу А,В,С үнэлгээнд хамруулах “Үйлчилгээний чанар, стандартыг үнэлэх шалгуур үзүүлэлт, аргачлал”-ыг боловсруулан Нийслэлийн Засаг даргын захиргаа, хууль эрх зүйн асуудал хариуцсан ахлах зөвлөх Д.Цолмонд танилцуулсан. Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | 70% |
| **54.** | | Ажлын хэсэг байгуулах тухай 2023.09.20 А/1113 | 1.Улаанбаатар хотын зарим хэсгийн орон сууцны барилгын хэрэгцээний ус хангамжийн шугам сүлжээнээс зэвтэй ус гарч, иргэд, оршин суугчдаас гомдол, хүсэлт ихээр ирж байгаатай холбогдуулан орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарын үйл ажиллагаа, шугам сүлжээнд хяналт-шалгалт хийж, цаашид зохион байгуулж, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар | Нийслэлийн нутаг дэвсгэрт байрладаг орон сууцны барилгуудын хэрэглээний усны шугам сүлжээнээс зэвтэй ус гарч буй асуудлаар хяналт шалгалт хийж хангагч болон захиалагч, ашиглалт хариуцсан нийт 10 аж ахуйн нэгж байгууллагад “Зэвтэй усны асуудлыг шийдвэрлүүлэх тухай” мэдэгдэл хүргүүлсэн. Шалгалтын үр дүнд цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулж ажлын хэсэгт танилцуулсан. | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, удирдамжийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай. | | |
| 55. | | Хяналт шалгалт хийх тухай 2023.11.02 А/1240 | Иргэд, оршин суугчдын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилгоор Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй нийтийн байрны орчин, нөхцөлд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулж, гарсан зөрчил дутагдлыг арилгуулах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор байгуулсугай. | Нийтийн байрны үйл ажиллагаа, барилга байгууламж, эрүүл ахуйн төлөв байдал, орчны болон хөрсний бохирдол, хог хаягдал, нийтийн хэв журам, галын аюулгүй байдлын стандарт, норм нормативын хэрэгжилтэд хяналт тавих, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах зорилгоор нийт 486 нийтийн байранд үзлэг шалгалт хийж Хотын стандарт, хяналтын газрын Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагчийн гаргасан 02-1301/026/149 дугаартай Урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх тухай, мөн Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагчийн гаргасан 11-13-02/052/65 дугаартай Эрчим хүч ашиглагчдад аюулгүй байдлыг хангаж ажиллах тухай зөвлөмжийг тус тус хүргүүлсэн. | 100% |
| 56. | | Хяналт шалгалт хийх тухай 2023.11.02 А/1267 | 1.Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, байгаль орчин, хүний эрүүл мэндэд хог хаягдлаас үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, авто замын түгжрэлийг саарлуулах зорилгоор тээврийн хэрэгслийн улсын дугаараар замын хөдөлгөөнд оролцуулах хязгаарлалт тогтоосон бүсчлэлд хамаарах зам дагуу авто үйлчилгээ, хоёрдогч түүхий эд худалдан авах цэг, барилгын материалын худалдаа, үйлчилгээ явуулж байгаа нь хууль тогтоомж зөрчсөн эсэхийг тогтоох төлөвлөгөөт | Баянзүрх дүүрэг болон Баянгол, Хан-Уул, Сүхбаатар дүүргүүдэд барилгын материалын худалдаа, үйлчилгээ явуулж буй иргэн, аж ахуйн нэгжүүдэд хамтарсан хяналт шалгалт хийж тохирлын гэрчилгээгүй бараа бүтээгдэхүүн худалдан борлуулж байсан зөрчлийг илрүүлж 1 иргэнд зөрчлийн хэрэг бүртгэлийн ажиллагааг явуулж, 500 мянган төгрөгийн торгууль тавьж, гүйцэтгэлийг хангуулах, ЭБАТ-ны зөрчил арилгуулах тухай албан даалгавар хүргүүлж, нийслэлийн Прокурорын газрын хяналтын Прокурорт хянуулж ажиллалаа. Мөн барилгын материалын худалдаа эрхлэгч **380** гаруй иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад Улсын байцаагчийн 2023.11.15-ны 02-13-01/040/184 тоот зөвлөмжийг хүргүүлэн ажилласан | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | бус хяналт шалгалтыг зохион байгуулсугай. | 2. Чингэлтэй болон Сүхбаатар дүүргийн зам дагуу авто үйлчилгээ эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс 11 дүгээр сарын 23-ны өдрүүдэд зохион байгуулсан. Хяналт шалгалтаар авто засвар 59, авто угаалга 8, дугуй засвар 15, авто сэлбэгийн худалдаа 7 нийт 138 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулж 450 гаруй зөрчил, дутагдлыг илрүүлсэн. Нийт 20 аж ахуйн нэгж, иргэнд "Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай" улсын /ахлах/ байцаагчийн албан шаардлага гаргаж, хугацаатай үүрэг даалгавар өгсөн. | |
| **Хэсгийн дундаж хувь: 94%** | | | | | |
| **АРВАН НЭГ. НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ** | | | | | |
| 57. | | 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 01 дүгээр хуралдааны тэмдэглэл | Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.8, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн $10^1$.1-д тус тус заасныг үндэслэн 7 бүлгийн 20 Хотын стандартыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьж, хэлэлцүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Захиргаа, хууль эрхзүйн асуудал хариуцсан Ахлах зөвлөх (Д.Мөнх-Эрдэнэ)-д үүрэг болгов". | 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдөр Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус 10 дугаар хуралдаанаар нийслэлийн хэмжээнд мөрдүүлэх хоёрдугаар ээлжийн 7 бүлгийн 14 хотын стандартыг хэлэлцүүлж батлуулав. Үүнд:<br>1. "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй дэд бүтэц" бүлгийн 2 хотын стандарт,<br>2. "Үер борооны усны байгууламж" бүлгийн 3 хотын стандарт,<br>3. "Гудамж, зам, барилга байгууламжийн хаягжилт" бүлгийн 1 хотын стандарт,<br>4. "Нийгмийн дэд бүтэц" бүлгийн 1 хотын стандарт,<br>5. "Бие даасан инженерийн дэд бүтэц" бүлгийн 2 хотын стандарт,<br>6. "Дуу чимээний бохирдол" бүлгийн 3 хотын стандарт,<br>7. "Барилгын хийц, эдлэхүүн, техник" бүлгийн 2 хотын стандарт тус тус багтсан. | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| 58. | | 2023 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 03 дугаар хуралдааны тэмдэглэл | Барилгыг албадан буулгах санал, шийдвэр боловсруулах ажлын хэсэг байгуулж, холбогдох шийдвэрийг гаргуулж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч (Ж.Сандагсүрэн)-д үүрэг болгов" гэжээ. | Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/288 дугаартай захирамжаар Ажлын хэсэг байгуулж, нийслэлийн хэмжээнд барилгын ажлын зөвшөөрөлгүйгээр барилга угсралтын ажлыг эхэлсэн 55 иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавьж, холбогдох санал, дүгнэлтийг боловсруулж, үр дүнг Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 11 дугаар хуралдаанд танилцуулсан. | 100% |
| | | | Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.4 дүгээр зүйлийн 5 дахь заалт (Зөрчлийн үр дагаврыг арилгах тухай эрх бүхий албан тушаалтны даалгаврыг зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд биелүүлээгүй, эсхүл энэ арга хэмжээний зардлыг тогтоосон хугацаанд төлөөгүй бол шүүхэд хүсэлт гаргаж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар албадан гүйцэтгүүлнэ.)-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлж, албадан гүйцэтгэх арга хэмжээ авахуулах Шүүгчийн шийдвэр гаргуулахыг Хотын стандарт, хяналтын газар (С.Төмөрдулам)-т үүрэг болгов" | Барилгын ажлын зөвшөөрөлгүйгээр барилга угсралтын ажлыг эхлүүлсэн 55 барилгаас 11 иргэн, хуулийн этгээдэд Нийслэлийн Мэргэжлийн хяналтын байгууллагаас хялбаршуулсан хэрэг үүсгэн барилга угсралтын ажлыг зогсоох тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг биелүүлээгүй тул Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд дээрх шийдвэрийг албадан гүйцэтгүүлэхээр 2021-2022 онд хүргүүлсэн.<br>Бусад зөвшөөрөлгүй барилга байгууламжийн ажлын гүйцэтгэл, холбогдох баримт бичгийг судлан Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/288 дугаартай захирамжаар байгуулсан ажлын хэсэгт танилцуулан хуралдаанаас гарсан шийдвэрийг үндэслэн шүүхийн байгууллага руу хэргийг шилжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. | 70% |
| 59. | | 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 11 дүгээр хуралдааны тэмдэглэл | 1.Хот байгуулалтын тухай, Барилгын тухай, Газрын тухай болон холбогдох хууль, тогтоомж, барилгын норм ба дүрмийг зөрчиж | Нийслэлийн хэмжээнд холбогдох хууль, тогтоомж, барилгын норм ба дүрмийг зөрчиж 20 хуулийн этгээдийн 35 барилга байгууламжийг салбарын Ерөнхий байцаагчийн дүгнэлт гаргуулахаар хүргүүлж, Барилга, хот байгуулалтын яамны 2023 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 6/3237, 2023 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 9/3386 дугаартай албан бичгүүдийн дагуу барилга байгууламжийн чанар, стандартад нийцээгүй 17 барилгад Барилгын техникийн хяналтын улсын /ахлах/ байцаагчийн 17 ширхэг дүгнэлтийг | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | | гарган салбар яаманд хүргүүлж, Барилга, хот байгуулалтын яамны Салбарын Улсын Ерөнхий байцаагчийн 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 02-00-00/001/01 дугаартай дүгнэлтийг гаргуулан хэрэгжилтийг бүрэн хангуулсан. | |
| 60. | | 2023 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн 15 дугаар хуралдааны тэмдэглэл | Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалт, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн $10^1$ дугаар зүйлийн $10^1$.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Хотын стандартыг батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах журмын төслийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд өргөн мэдүүлж, хэлэлцүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Захиргаа, хууль эрх зүйн асуудал хариуцсан ахлах зөвлөх (Д.Мөнх-Эрдэнэ)-д үүрэг болгов. | Нийслэлийн удирдлагууд солигдсонтой холбогдуулан уг журмын төслийг 2023 онд багтаан Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанд дахин хэлэлцүүлэхээр шийдвэрлэж бэлтгэл ажлыг хангаж байна. | 70% |
| **Хэсгийн дундаж хувь: 88%** | | | | | |

## БИЕЛЭЛТИЙН ТОВЧООН

| **Д/д** | **Хууль, тогтоол, шийдвэрүүд** | **Хэрэгжилтийн хувь** |
|---|---|---|
| 1. | Монгол Улсын 6 хуулийн 25 заалтын дундаж | 99.2% |
| 2. | Монгол Улсын Их хурлын 1 тогтоолын 2 заалтын дундаж | 90% |
| 3. | Монгол Улсын Ерөнхийлөгчийн 3 зарлигийн 3 заалтын дундаж | 100% |

| | | |
|---|---|---|
| 4. | Монгол Улсын Засгийн газрын 13 тогтоолын 22 заалтын дундаж | 97.7% |
| 5. | Монгол Улсын Ерөнхий сайдын 1 захирамжийн хэрэгжилт | 90% |
| 6. | Монгол Улсын Засгийн газрын хуралдааны 9 тэмдэглэлийн 11 заалтын дундаж | 96.3% |
| 7. | Монгол Улсын Засгийн газар болон Ерөнхий сайдын 3 албан даалгаврын 3 заалтын дундаж | 100% |
| | **Хэсгийн дундаж:** | **96.18%** |
| 8. | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 7 тогтоолын 7 заалтын дундаж | 90% |
| 9. | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 1 хуралдааны тэмдэглэлийн 4 заалтын дундаж | 90% |
| 10. | Нийслэлийн Засаг даргын 10 захирамжийн хэрэгжилт | 94% |
| 11. | Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралдааны 4 тэмдэглэлийн 5 заалт | 88% |
| | **Хэсгийн дундаж:** | **90.5%** |
| | **НИЙТ ХЭРЭГЖИЛТ:** | **93.34%** |

**ТАНИЛЦСАН:**
ГАЗРЫН ДАРГА С.ТӨМӨРДУЛАМ

**ХЯНАСАН:**
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Э.ДАВААХАТАН

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:**
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН С.БОЛДОО

**БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН:**
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ, ТАЙЛАН ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН М.ГАЧМАА